

**“МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТАЛСАНТАЙ
ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” МОНГОЛ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар ✓

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.7 дахь хэсгийг үндэслэн боловсруулсан “Монгол улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэн дэмжиж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр Та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлд Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайланд дурдагдсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, нийтлэг болон давтан гарч байгаа алдаа, зөрчлийн бодит шалтгааныг судалж тэдгээрийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулахтай холбоотой болон хууль эрх зүйн зохицуулалтын талаар санал боловсруулж танилцуулахыг Засгийн газарт даалгахаар тусгасан. Мөн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн олон жилийн насжилттай, зээлийн хугацаа хэтэрсэн болон найдваргүй болох эрсдэлтэй зээлийн авлагын үлдэгдлийг тодорхойлох асуудлаар төрийн аудитын байгууллага нь аудитын стандарт, холбогдох хууль тогтоомжийн нийцлийг хангаж ажиллахыг Монгол Улсын ерөнхий аудиторт даалгасан.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат төсөлд тусгагдсан Улсын Их Хурлаар зөвшөөрч шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн өмчит аж ахуй нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд үндсэн үйл ажиллагаанаас бусад чиглэлээр зарлага гаргахыг хязгаарлаж байгаа нь бодит нөхцөлд нийцэхгүй байгааг анхаарах, төрийн өмчит компаниуд тодорхой асуудлын хүрээнд нийгмийн хариуцлага хүлээх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал төрийн өмчийн хуулийн этгээдүүд ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг тул тухайн байгууллагууд арилжааны шинжтэй үйл ажиллагааг хориглох нь зүйтэй эсэх талаар асууж, санал хэлсэн болно.

Дэд хорооны хуралд оролцсон гишүүдийн олонх “Монгол улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА



ДА.ЦОГТБААТАР